

## КАНАД УЛС БА МОНГОЛ-КАНАДЫН ХАРИЛЦАА

*Д.Өүлэн-Үжин\**

Дэлхийд газар нутгийн хэмжээгээр хоёрт орох энэ улсын нийт талбайн хэмжээ нь 9,970,610 хавтгай дөрвөлжин километр юм. Цаг агаарын хувьд манай оронтой адил жилийн 4 улиралтай бөгөөд агаарын температурын хэлбэлзэл багатай боловч өргөн уудам нутагтайн хувьд зундаа 35 С хүртэл халж өвөлдөө -25 С хүртэл хүйтрэх үе ч бий. Газар нутгийн хувьд өргөн уудам тал нутгаас гадна өндөр уулс, шигүү ой нуур цөөрөм гээд л байгалийн үзэсгэлэнт газрууд олон.

Канад нь засаг захиргааны хувьд 10 мужид хуваагдах агаад томоохон хотуудын тоонд Торонто, Монреаль, Ванкувер, Эдмонтон орно. Нийслэл хот нь Оттава.

Агч модны навчны дүрсийг төрийн сүлдэндээ залсан ардчилсан парламенттай Холбооны улс болох Канад улсын Парламент нь Сенат, Нийтийн танхим гэсэн 2 хэсгээс бүрддэг бөгөөд гишүүдээ 5 жилийн хугацаагаар сонгодог. Дээд танхим буюу Сенат нь бүс нутаг мужуудыг төлөөлсөн 105 гишүүнтэй харин Нийтийн танхим нь 305 гишүүнтэй. Эдгээр гишүүдийг Ерөнхий сайдын зөвлөмжөөр Амбан захирагч томилно. Харин Амбан захирагчийг Ерөнхий сайдын саналаар 5 жилийн хугацаагаар Канадын англичууд болон францчуудын дундаас ээлжлэн сонгож томилох ба Амбан захирагч нь Их Британийн Хатан хааны бие төлөөлөгч юм. Амбан захирагчийн ажлын албанд бүх сайдуудаас бүрдсэн зөвлөл ажиллана.

Хүн амын нийт тоо нь 31.83 сая /2005 оны байдлаар/ бөгөөд хүн амын дийлэнх хэсэг буюу 76.6 хувь нь хот суурин газар, 23.4 хувь нь хөдөө орон нутагт оршин суудаг. Канадчуудын дийлэнх нь буюу 55 орчим хувь нь католик шашинтан бөгөөд үлдсэн хэсгийг нь протестант болон бусад шашин эзлэнэ. Англи, франц гэсэн албан ёсны хоёр хэлтэй энэ улсын 16.1 сая хүн англи хэлээр, 6.5 сая хүн франц хэлээр ярьдаг бол үлдсэн хувь нь итали, герман, португаль, польш, украин, хятад, грек хэлээр ярьдаг.

Хүн амын дундаж наслат харьцангуй өндөр буюу эмэгтэйчүүдийнх 83.5 эрэгтэйчүүдийнх 76.6 юм байна. Амьдралын түвшингээр ч мөн дэлхийд дээгүүр байранд орох ба өрхийн жилийн дундаж орлого нь 73.200 ам.доллар аж. Ажилгүйдлийн түвшин 7.3 хувь, инфляцийн хэмжээ нь 2.5 хувьтай байдаг энэ орны дотоодын нийт бүтээгдэхүүн 2005 оны байдлаар 1.2 триллион канад доллар байгаа нь ихээхэн өндөр үзүүлэлт юм. /100 канад доллар 1 ам.доллартай тэнцдэг/

\* Д.Өүлэн-Үжин - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Хөдөө аж ахуй, газар тариалан бол эдийн засгийн гол салбар бөгөөд дотоодын үйлдвэрлэл, тэр дундаа хүнс, эм, эмнэлгийн багаж төхөөрөмж, нийлэг эдлэл, хүдэр олборлолт, боловсруулалт, цөмийн эрчим хүч, микроэлектроник, электроникийн эд ангиуд, биотехнологи, цаас болон, машин тоног төхөөрөмж зэрэг аж үйлдвэрийн салбар нь өндөр хурдтай хөгжиж эдүгээ аж үйлдвэрийн дэлхийд тэргүүлэх 7 орны нэг болж чаджээ.

Автомашин үйлдвэрлэл, мод боловсруулалт, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, уул уурхай өндөр хөгжсөн тус улс байгалийн баялгийн хувьд ч чамгүй нөөцтэй агаад үүнд байгалийн хий, алт, зэс, никель, уран, цинк, газрын тос, нүүрс орно.

Тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 74 хувийг гадаад худалдаа эзэлдэг ба гадаад худалдааны тэргүүлэх чиглэл нь АНУ-тай иж бүрэн түншлэлийн хэмжээнд харилцаатай байх явдал юм.

Экспортын хувьд автомашин, дагалдах сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүнд механизм, байгалийн хий, газрын тос, төмөрлөгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, ойн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зонхилдог бол импорт нь аж үйлдвэрийн тоног төхөөрөмж, үнэт металл, хуванцар эдлэл, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн болон хүнсний бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Уул уурхайн салбарын томоохон хөрөнгө оруулагч болох Канад улстай Монгол Улс анх 1973 оны 11-р сарын 30-ны өдөр дипломат харилцаа тогтоосон юм.

Хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг улам идэвхжүүлэх үүднээс Канадын тал 1997 оны 12-р сарын 1-нд Улаанбаатар хотод Өргөмжит Консулын газраа нээсэн бол манай улс 1998 онд Торонто хотноо Ерөнхий Консулын газраа нээн ажиллуулж байгаад 2001 оны 12-р сарын 1-нд Оттава хотноо Элчин сайдын яам болгон өргөжүүлсэн байна.

1998 оны 9-р сард Гадаад хэргийн сайд Р.Амаржаргал Канадын Гадаад хэргийн сайд Л.Эксворди нар Оттава хотноо “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Тунхаглал”-д гарын үсэг зурснаар Монгол, Канадын харилцааны ерөнхий зарчмыг тодорхойлов.

Уг тунхаглал хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа цаашид өргөжин хөгжихөд чухал түлхэц болсон юм.

2000 оны 9-р сард Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Нью-Йорк хотод ажиллах хугацаандаа Канадын Гадаад хэргийн сайд ноён Л.Эксвордитай уулзан хоёр орны харилцаа хамтын ажиллагааны талаар санал солилцов. Мөн тэд тус тусын орны Засгийн газрын мөрийн хөтөлбөр, гадаад бодлогынхоо талаар товч мэдээлж хоёр орны харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ сайд Л.Эрдэнэчулуун Канадад Элчин сайдын яам нээн ажиллуулахаар шийдвэрлэсэн тухайгаа мэдээлжээ.

2001 оны 4-р сард Канадын Ази, Номхон далайн асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга ноён Рей Пактохан, 9-р сард тус яамны Хятад, Монголын газрын дарга Ж.Моррисон тэргүүтэй төлөөлөгчид манай оронд тус тус айлчлав. Мөн онд Канадын тал санхүүгийн жилд зориулан албан ёсны тусламжаа 300 мянган канад доллар болгон нэмэгдүүлж, 2002 оноос жилдээ 20 оюутанг солилцооны шугамаар хүлээн авч байхаар боллоо.

2002 оноос Канад Монголын харилцаа нэлээд идэвхжив. Нью-Йорк хотноо болсон Дэлхийн эдийн засгийн чуулганы үеэр Монгол Улсын Ерөнхий сайд, Канад улсын Ерөнхий сайд нар танилцах уулзалт хийсэн нь хоёр улсын харилцааны түүхэн дэх Ерөнхий сайд нарын анхны уулзалт болсон юм.

Хоёр орны Гадаад хэргийн яамдын хооронд зөвлөлдөх механизмыг тогтмолжуулах хүрээнд Брунейд болсон АРФ-ийн сайд нарын уулзалтад оролцох үеэрээ манай улсын Гадаад хэргийн сайд Канадын Гадаад хэргийн сайдтай уулзаж харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Үйлдвэр худалдааны сайд, хүнс хөдөө аж ахуйн сайд нар Канад улсад тус тус айлчилж хамтын ажиллагааны хэлэлцээр болон бусад баримт бичигт гарын үсэг зурсан нь хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулах, улмаар хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэгдсэн ач холбогдолтой алхам болов.

2002 оны 7-р сард Канадын Гадаад хэргийн сайд асан Л.Эксворди Монгол Улсад айлчилсан явдал нь Канадын улс төрийн хүрээнд өөрийн хүнтэй болох, хоёр талын хамтын ажиллагааг урагшлуулахад тус дөхөм үзүүлэх, Канадын өндөр албаны хүмүүстэй хэлхээ холбоо тогтооход нөлөөлөх үүднээс чухал ач холбогдолтой болсон юм.

Канадын талаас манай улсад өгөх тусламжаа нэмэгдүүлж 300 мянган канад доллар байсныг 2002 онд 500 мянга болгох шийдвэр гаргав. Мөн үүний зэрэгцээ аж үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд тусламж үзүүлж эхлэв.

2004 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Канад улсад төрийн айлчлал хийсэн нь өөрийн орныг Канадын дээд удирдлага олон нийтэд танилцуулах, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсны дээр айлчлалын үр дүнд “Өргөн хүрээтэй түншлэлийн тухай хамтарсан мэдэгдэл” гаргаж, “Ялтан шилжүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Канад улсын Засгийн газар хоорондын гэрээнд гарын үсэг зурав. Мөн тус ондоо Канадын Колумбийн Их сургуультай “Багш, эрдэм шинжилгээний ажилтан, оюутан солилцооны хөтөлбөр

боловсруулах гэрээ зэрэг боловсролын салбарт хамтран ажиллахаар төслийн хэмжээнд бэлэн болгосон байна.

2006 оны 10-р сард Канадын Парламентын Нийтийн танхимын спикер П.Милликон Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны харилцааг улам хөгжүүлэхэд чухал алхам болсон юм.

Монгол, Канад хоёр орны хооронд төр засгийн болон худалдаа бизнесийн харилцаа өргөжин тэлэхийн хэрээр хүн солилцоо ч хурдацтай нэмэгдэж байна. 2001 онд Канадаас Монголд 163 хүн зорчиж байсан бол 2004 оны эхний хагаст 446 болж, 2003 оны байдлаар Монголоос 146 хүн Канадад зорчжээ.

1996 оноос хойш Канадаас манай улсад оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээ 175,45 сая ам долларт хүрсний ихэнх нь уул уурхайн салбарт ногдож байна.

Мөн Монгол Улс 1997 онд Канадын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламжид хамрагдсанаас хойш нийт 4,2 сая ам.долларын тусламж авчээ. Үүнээс гадна Канадын Засгийн газар байгалийн гамшигтай тэмцэхэд зориулж 2001 онд 30000 ам доллар, SARS-тай тэмцэхэд зориулж 2003 онд 20000 ам.доллар, мөн оны АШСТО-ны 5-р бага хуралд 200000 канад долларын буцалтгүй тусламж тус тус олгосон байна.

Мөн хоёр орны худалдааны харилцаа сүүлийн үед эрчимтэй хөгжиж байгаа нь манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 6.3 хувийг Канад улс эзэлж байгаагаас харж болно. 1995 онд хоёр орны нийт бараа эргэлт 0.1 сая ам.доллар байсан бол 2006 онд 181 сая ам.доллар болсон нь том амжилт юм.

Хоёр орны экспорт импортын хэмжээ ч урьд өмнөх онуудаас эрс өссөн бөгөөд манай улсаас Канад улсад экспортлох экспортын хэмжээ 1995 онд 0.1 сая ам.доллар, импортын хэмжээ 0.03 сая ам.доллар байсан бол 2006 онд экспортын хэмжээ 171.2 сая ам.доллар, импортын хэмжээ 9.9 ам.доллар болж өсчээ.

Хоёр орны харилцаа хамтын ажиллагаа улам өргөжин тэлж байгааг соёл боловсрол, уул уурхай, шинжлэх ухаан, батлан хамгаалахын салбар болон бусад салбар дахь хамтын ажиллагаанаас харж болно.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Монгол Улсын статистикийн эмхтгэл. УБ, 2006 он
2. Канад улс, Монгол Канадын харилцаа /ГХЯ/
3. Lonely planet /Canada 2005/
4. [www.mongolembassy.org](http://www.mongolembassy.org)
5. [www.mongolia-foreign-policy.net](http://www.mongolia-foreign-policy.net)
6. [www.international.gc.ca](http://www.international.gc.ca)